



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/01

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Хүүхдийн хөгжил хамгааллын жил болгон зарлах тухай” 2017 оны 06/05 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “2018 оныг зорилтот жил болгон зарлах тухай” 2017 оны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, сумын 2018 оны зорилтот “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд: Мал эмнэлэг, хүнс худалдааны хяналтын улсын байцаагч

Төрийн захиргааны түшмэл

Нийгмийн бодлогын асуудал хариуцсан түшмэл

Хөдөлмөр эрхлэлт хариуцсан түшмэл

Насан туршийн боловсролын арга зүйч

Сургуулийн өмнөх боловсролын арга зүйч

Нягтлан бодогч

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажилтан

Хэвлэл, мэдээлэл сүлжээний ажилтан

Нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн

Сум хариуцсан нийгмийн ажилтан

Багийн Засаг дарга нар

Багийн зохион байгуулагч нар

Багийн Нийгмийн ажилтнууд

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон

ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтнууд

Өрхийн эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн

нийгмийн ажилтан

2. Иргэд, олон нийтийн саналд тулгуурлан зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, ажил үүргийн хуваарь гарган хэрэгжилт, үр дүнгийн тухай сонголт мэдээллийг хагас жилд сумын Засаг даргын зөвлөл, жилийн эцэст иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдөд тус тус тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

371100001

D/2017 on bichig hereg-zahiramj-2017